

# 3

## ЭЛЕКТРОН ХУДАЛДААНЫ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Т. Кавал

"Электрон худалдаа" гэсэн ойлголт нь бидний амьдралд аль хэдийний танил зүйлийн нэг болоод байгаа билээ. Бид кассын машин, нябо бүртгэлийн тайлангаа утсаар өгөхөөс татгалзаад удсан билээ. Бизнесменүүд болон албан байгууллагуудад электрон худалдаа нэвтэрч бизнесийн стратегийн хувьд тэд худалдааны шинэ орчинг сонгоод байгаа болно. Манай оронд INTERNET нэвтэрснээр, түүний дотор World Wide Web (WWW) өргөн хүрээтэй хөгжиж байна. Пүүс болон фирмүүд компьютерийн орчинд буюу мэдээллийн шинэ технологийг чухалд тооцох боллоо. Ийнхүү электрон худалдааны шинэ зуун эхэллээ.

Электрон худалдаа гэж юу вэ?

Электрон худалдаа гэдэг нь компьютер, телеболовсруулалтын шинэ технологи ашиглан бараа, бүтээгдэхүүнийг компьютерийн программ ашиглан худалдах, худалдан авах худалдааны шинэ арга юм. Электрон худалдаа нь мэдээллийн технологийн electronic data interchange (EDI), electronic mail (e-mail), electronic funds transfer (EFT) - технологиудыг ашигладаг байна. Худалдан авагч ба худалдагч 2-ын хооронд электрон худалдааны харилцаа (relationship) үүсгэдэг юм.

Бизнесменүүд электрон худалдааг яаж хийдэг вэ?

Электрон худалдааны сервизүүд, интернет кафенууд болон маш олон албан байгууллага компьютер, программ хангамжийг янз бүрээр хэрэглэж байна. Бизнесменүүд худалдаандаа WWW-ыг ашиглаж бараа, бүтээгдэхүүнийхээ каталог,

үнийн жагсаалт, брошюруудыг дэлгэцээр харуулж сурталчлан ажиллаж байна. Интернэтээр дамжуулан тэд бизнесээ шууд хийдэг ба улсынх нь хуульд электрон худалдааны бүлэг тусгагдсан байна. Маш өндөр хөгжилтэй олон компаниуд программ хангамж ба техникийн бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд үүрэг гүйцэтгэж 24 цагийн дотор хэрэгцээтэй программ хангамжаа шууд авч хэрэглэх бололцоогоор хангадаг байна. Тэдгээрийн үнийг электрон картуудын тусламжтайгаар шууд гуйвуулдаг юм. Электрон худалдааны шинэ технологи нь байгууллагуудын хоорондох бичиг баримтуудын солилцоо, тухайлбал харилцан итгэл үнэмшил, санхүү, худалдааны гэрээ хэлцэл, татвар, хууль, даатгалын солилцоон дээр үндэслэгддэг. Электрон худалдаа нь худалдан авагч ба худалдагч талуудад хоёуланд нь үр ашигтай байдаг бөгөөд цаасны ажил, удирдлагын менежментийг сайжруулдаг юм. Жишээлбэл цаг хугацаа хэмнэдэг, хурдан шуурхай, алс холоос үл хамаардаг зэргийг дурдаж болно. Манай Монгол улсад Датаком компани нь ийм мэдээллийн шинэ технологийг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

### Электрон худалдааны үүрэг

Электрон худалдаа нь орчин үеийн бизнесийн арга бөгөөд байгууллага, худалдаачин, худалдан авагч бараа бүтээгдэхүүн, сервис үйлчилгээгээ цаг хугацаа хэмнэн алсын зайнаас хурдан шуурхай худалдах, гүйлгээ хийх сонгодог арга юм. Энэ ухагдахуун нь компьютерийн сүлжээ, мэдээллийг эрж хайх, эргүүлэн үр дүнг нь хүлээж авах хүн ба үйлдвэрлэл хоорондын шийдвэр гаргах цогц юм. Электрон худалдааны мэдээллийг боловсруулах процесс нь дараах ажил, гүйлгээ, үйлдлүүдэд хуваагдана.

Үүнд:

1. Компаниуд ба худалдан авагч хоорондын кредит карт, электрон касс ашиглан гүйлгээ хийх хувийн дэлгүүр, банкны сүлжээ
2. Худалдааны түнштэйгээ EDI ашиглан хийх гүйлгээ
3. Худалдааны мэдээллийг цуглуулах, мэдээлэлд шинжилгээ хийх, байгууллагын асуудлуудыг шийдвэрлэх, удирдлагын оновчтой шийдвэр гаргах
4. Идэвхитэй худалдан авагчтайгаа хамтын дистрибутер худалдаа зохион байгуулах, худалдаа бизнесийн реклам, зар сурталчилгааг хүчтэй болгох.

Энэ худалдааны үйл ажиллагаа нь интернеттэй шууд хамааралтай явагдаж байна. Өнөөдөр 130 орны 10 сая хүмүүс интернетэд холбогдоод байна.

**# Electronic Commerce-ын технологиуд** (Цаашдаа electronic commerce буюу EC гэж нэрлэв).

EC нь нилээд хэдэн технолог хэрэглэдэг. Үүний зарим хэсгээс дурдвал:

1. Electronic data interchange (EDI)
2. Bar codes
3. Electronic mail
4. Internet
5. World Wide Web
6. Product data exchange
7. Electronic forms.

### 1. Electronic Data Interchange (EDI)

EDI нь стандарт электроник хэлбэрээр компьютер-ээс компьютерт бизнесийн мэдээллийг харилцан солилцох арга юм. Мэдээлэл нь компьютер дээр байх бөгөөд тусгай программаар EDI хэлбэрт хөрвөж нэг ба хэд хэдэн худалдааны түншүүдэд дамждаг.

### 2. Bar Codes

Bar cod нь компьютерын тусламжтайгаар бараа бүтээгдэхүүнд тавьсан тодотгол тэмдэг юм. Эдгээр нь янз бүрийн хэмжээтэй шулуунуудын тэгш өнцөгт дүрст загвар, 0-9 хүртэл цифрүүдээс тогтсон тэмдэгт бөгөөд лазерын гэрэл ойж тусахад компьютер мэдэрч байхаар хийгдсэн байна.

### 3. Electronic Mail

Message-ууд нь ямар нэгэн хувь хүнээс тоон хэлбэрээр интернетийн тусламжтайгаар дамжина.

### 4. Internet

Интернет нь сая сая хүн ба компьютерүүд холбогдсон ерөнхий сүлжээ юм. Энэ сүлжээнүүд нь TCP/IP (Transmission control protocol/Internet protocol)-оор зөвшөөрөгдсөн нийтийн холбооны сүлжээ бөгөөд хүн ба бизнес хоорондын холбооны хэрэгсэл болдог. Энэ сүлжээ маш хурдтай хөгжиж маш олон хүмүүсийг эгнээндээ хамарч байна.

### 5. World Wide Web

Hypertext Markup Language (HTML ) хэлээр бичигдсэн документуудийн цуглуулга юм. Хэрэглэгч "browser" гэж нэрлэгдэх жижиг программын тусламжтайгаар web page гэж нэрлэх янз бүрийн мэдээлэлтэй холбогдон ажиллана. Энэ хуудас нь текст, зураг, видео, дуу зэрэг янз бүрийн хэлбэртэй байна. Ийм учраас энэ хуудсууд нь интернетээр дамжин худалдаа явуулах, сурталчлах үүргийг гүйцэтгэнэ.

### 6. Product Data Exchange

Бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дамжуулдаг. Зарим тохиолдолд график хэлбэрээр илэрхийлэгддэг. Энэ нь бусад бизнесийн төрлүүдээс 2 гол ялгаатай байдаг. Үүнд:

- ◆ Графикууд нь маш том файл байдаг учир хэрэглээний зориулалтын программ шаардлагатай болдог.
- ◆ Бараа, бүтээгдэхүүнийг тодорхойлох компиляци нь ярвигтай, удаан байна.

### 7. Electronic Forms

Энэ нь баримт, документайн электрон цаасны технологи юм.

### Электрон худалдааны хэлбэрүүд:

- ◆ Telephone Banking (телефон банк)
- ◆ Interac (харилцан ажиллагаа)
- ◆ Credit cards (кредит карт)

- ◆ PC Quote Services (компьютерийн сервис)
- ◆ Direct deposits (шууд хадгаламж)
- ◆ EDI (Electronic Data Interchange)

**Хамгийн ашигтай тал нь:**

- ◆ Цаасны ажиллагааг багасгана.
- ◆ Захиргааны гүйцэтгэх цагийг хэмнэнэ.
- ◆ Худалдааны агентлагууд үр ашигтай болохыг хүлээн зөвшөөрдөг.
- ◆ Мэдээлэлтэй маш түргэн хурдтай харьцдаг.

**Төлбөрийн хэрэгслүүд:**

Электрон тооцооны касс

- ◆ Зөвшөөрөгдсөн нэргүй төлбөрийн хэрэгслүүд (касстай төстэй)
- ◆ Мөнгөн тэмдэгттэй адил чанартай кодчилогдсон message.
- ◆ DigiCash
  - Сайжруулан хөгжүүлсэн карт(Smart Cards)

Клирингийн төлбөр

- ◆ CyberCash компани анх оруулж ирсэн
- ◆ Яаж ажилладаг вэ?
  - хэрэглэгч программыг татаж оруулна.
  - хэрэглэгч тооцоог кредит мэдээллийн хамт оруулна.
  - худалдагч нэмэлт мэдээллийг өгнө.
  - CyberCash server үйлдлийг гүйцэтгэнэ.

Smart Card-ууд

- ◆ Хөрөнгө эзэмшлийн систем
- ◆ Электрон түрийвч
- ◆ Тусгай терминалууд
- ◆ Interac-тай ижил картууд

Credit Card-ууд

- ◆ Хамгийн өргөн ашигладаг систем
- ◆ Хэрэглэгч кредит картын дугаараа оруулна.
- ◆ Дугаарыг шалгана.
- ◆ Үйлдлийг гүйцэтгэнэ.

**E-commerce-ийн бүтэц, тогтолцоо**

3 үндсэн логик үе шат:

- ◆ Хандах механизмууд
  - Электрон худалдааны системд хандах программын хэрэгсэл (www browser)
- ◆ Нөөцийн үе шат
  - Бараа, үйлчилгээний дамжуулах, наймаалцах (shipping, payment)
- ◆ Middleware (дунд үе)
  - Аюулгүй байдал, төлбөрийн механизм, тооцооны алгоритмууд.

**E-commerce-ыг бүтээгчид**

Оролцсон компаниуд:

- ◆ MasterCard
- ◆ Visa
- ◆ Технологийн түншүүд
  - GTE
  - IBM
  - Microsoft
  - Netscape
  - SAIC
  - Terisa Systems
  - Verisign.

**SET**

- ◆ Электрон ажил, гүйлгээний нууцлал, аюулгүй байдал
- ◆ Электрон худалдааны үйлдвэрийн стандарт
- ◆ Үйлчлүүлэгчийн интернет төвтэй электрон ажил, гүйлгээний итгэлцлэл
  - Интернетээр үйлчлүүлэгчдийн 88% нь электрон худалдаа хийж байна.
  - Интернетээр үйлчлүүлэгчдийн 97% нь кредит карт нь хулгайн байхаас эмээдэг.

**SET-ийн ашиг тус**

- ◆ Электрон худалдааны нууцлалыг ашиглаж Интернет худалдаанд худалдаачид айдсаас сэргийлнэ.
- ◆ Электрон худалдааны нууцлалыг ашиглаж худалдаачин hackers-уудаас хамгаалагдана.
- ◆ MasterCard ба Visa картыг голчлон ашиглахыг зорино.
- ◆ IBM, Microsoft, ба бусад нөлөөтэй компаниудын сервер, бүтээгдэхүүнүүдийг ашиглана.

**Microsoft-ын арилжааны сервер**

- ◆ 1999 оны 8-р сард хийгдсэн
- ◆ Дурын WWW browser-тэй ажиллана.
- ◆ Кредит картын төлбөр хийгддэг.
- ◆ Интернет дэх гүйлгээг уламжлалт утгаар нь хийнэ.
- ◆ Татвар ба ачаа, тээврийн зардлыг нь шууд хийнэ.

### Netscape Commerce - өргөтгөлүүд

- ♦ Бэлэн цуглуулгын сервер
- ♦ Хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй
  - LiveWire Pro:
    - relational database-тай ажилладаг
    - visual буюу харагдах орчны менежментийн хэрэгслүүдтэй
    - жижиглэн худалдаа, санхүү, хэвлэх, реклам зарын хэрэгслүүдтэй.
  - Live Payment:
    - санхүүгийн ажил, гүйлгээг нэгтгэнэ.
    - Кредит процесс нь тодорхой хугацаанд **online** байна.

### НИЙГМИЙН МАРГААНТАЙ АСУУДАЛ

#### Зохицуулах маргаантай асуудлууд

- ♦ Төр засгийн зохицуулалт хангалттай бус
- ♦ Бусад нь хүнд суртал гаргадаг.
- ♦ Мөнгөний бодлогын асуудал, дарамт болдог.
- ♦ Глобалчлалын эдийн засаг бүрэлдэж байна.
- ♦ Зарим цөөнх хэсэгт улс төрийн ноёрхол газар авч байгаа.
- ♦ Сул хөгжилтэй орнуудын худалдаачдад хүнд хэцүү, хохиролтой.
- ♦ Потенциалын хувьд хар зах илүү үр ашигтай байх тохиолдол байна.

#### Худалдааны маргаантай асуудлууд

- ♦ Гэрээ хэлэлцээрт электрон гарын үсгийг зөвшөөрдөггүй хуультай байх.
- ♦ Улс нь бодлогын хувьд ийм худалдааг дэмждэггүй байх.

#### E-commerce-ийн ирээдүй

- ♦ Маргаашийн кредит карт нь жижиг компьютер байж болох юм.
- ♦ Электрон банк ба төлбөрийн автомат тооцоонд шилжинэ.
- ♦ Визийн касс ба электрон түрийвч нэвтэрнэ.
- ♦ **Online shopping** хөгжинэ.
- ♦ Аялал, жуулчлалын **Smart travel cards** хэрэглэгдэнэ.